Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед Голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийн хариу арга хэмжээнд АХБҮТ-ийн хамт олон шуурхай хариу арга хэмжээний 9 багт орж ажиллан 730 гаруй удаагийн дуудлагаар сэжигтэй болон батлагдсан тохиолдол байрласан тусгаарлан ажиглах байрны 410 өрөө, тусгай үүргийн нислэгээр голомтот бүс нутгаас эх орондоо ирсэн 28472 иргэдэд үйлчилж, 42877 ширхэг гар тээш, 785613 кг карго ачаа, 185 агаарын хөлөг, 1160 тээврийн хэрэгсэл, 31 галт тэрэг, 13 чингэлэг, Нийслэлд бүртгэгдсэн коронавирусын халдвар авсан иргэдийн явсан маршрутын дагуу тээврийн хэрэгсэл, үзвэр, худалдаа үйлчилгээний газар, супермаркетууд, их дээд сургуулийн хичээлийн болон дотуур байр, сургууль, цэцэрлэг, айл өрх зэрэг 410 гаруй объектод нийт 163088м² талбайд голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн (Хүснэгт 34).

Хүснэгт 34 . Ариутгал халдваргүйтгэл, цэвэрлэгээ үйлчилгээний ажлыг өмнөх 5 жилийн дундажтай харьцуулсан байдал


Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2020	5-н жилийн дундаж
Халдваргүйтгэсэн материал /ш/	16383	10082	10858	18146	38040	17862	15072.6
Хуурай халуунаар ариутгасан /ш/	24671	24075	30274	83170	63566	50192	45151.2
Угаасан шилэн эдлэл /ш/	23509	25288	31195	52968	54711	64341	26940.6
Хатаасан шилэн эдлэл /ш/	167	22206	24375	42709	43424	47549	18034.4
Цэвэрлэж халдваргүйтгэсэн талбай /м ² /	126013	93041	79972	13517	124650	138006	84735.2
Бөглөө /ш/	2672	3580	8724	6461	3580	4790	1966.4
Шинжилгээнд бэлтгэсэн Тампон /ш/	2518	3353	5282	5350	3353	5570	1844.8
Бор ут /ш/	1158	387	2065	1786	387	5375	386.4
Маск /ш/	257	262	621	887	262	606	156.2

5.1 Халдваргүйжүүлэлтийн хариу арга хэмжээ

Коронавируст халдвар /Ковид-19/-ын тохиолдол дотоодод бүртгэгдэж эхэлхээс өмнө буюу 2020 оны 1 дүгээр сарын 17-аас 12 дугаар сар хүртэл ЗӨСҮТ-ийн шуурхай хариу арга хэмжээний 10 баг 486 удаагийн дуудлагаар сэжигтэй болон батлагдсан тохиолдол байрласан 21 тусгаарлан ажиглах байрны 353 өрөө,


тусгай үүргийн нислэгээр голомтот бүс нутгаас эх орондоо ирсэн 13,969 иргэдэд үйлчилж, 31,347 ширхэг гар тээш, 393822 кг карго ачаа, 194 агаарын хөлөг, 1,146 тээврийн хэрэгсэл, 31 галт тэрэг, 13 чингэлэгт нийт хамгаалах хувцас хэрэглэл 1962 ширхэг, 0,06%-ийн жавелионы уусмал 20885 литр, нунтаг гипохлорид кальци 497 кг, гар халдваргүйжүүлэх бодис 111522 гр, Устөрөгчийн хэт исэлтэй сальфетка 26312 ширхэг тус тус зарцуулж нийт 1,405 объектод 118,409.4м2 талбайд голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэж дотоодод халдвар тархахаас урьдчилан сэргийлж ажиллаа (Зураг 45).

Зураг 45. 2020 оны нийт халдваргүйжүүлэлт объектоор



Мөн коронавирусээс урьдчилан сэргийлэх ард, иргэдэд зөвлөгөө өгөх зориолгоор 70284393 дугаарын утсыг 24 цагаар ажиллуулж, дуудлагад зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Зөвлөгөө мэдээлэл 1-10 сард тогтмол байсан бол 11 дүгээр сарын 11-ны өдөр анхны тохиолдол бүртгэгдснээс хойш нэмэгдсэн байна (Зураг 46).

Зураг 46. Шуурхай хариу арга хэмжээний багийн голомтын халдваргүйжүүлэлт зохион байгуулсан тоо




5.2 Биоүйлдвэрлэл

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Биоүйлдвэрлэлийн тасаг 2020 онд орон нутгийн ЗӨСТ-үүдийн захиалгыг төвийн захирлын 551 дугаар албан тоотын дагуу хүлээн авч бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг зохион байгуулж ажиллаа (Зураг 47).

Зураг 47. 2015-2020 оны биоүйлдвэрлэлийн лабораторид үйлдвэрлэсэн биобэлдмэлийн тоон үзүүлэлт

№	Тэжээлт орчин	хэмжих нэгж	Он					Өмнөх 5 жил дундаж	2020
			2015	2016	2017	2018	2019		
1	Үндсэн	литр	1551	1285	1369	1165.6	1408	1355.7	909.8
2	Ялган оношлох	литр	203	220	217	218.92	361	243.9	252.673
3	Будаг, урвалж	литр	639	607	607	490.865	508	570.3	537.619
4	Нян залгиур	мл	705	720	514	760	540	647.8	500
5	Будаг шингээсэн цаас	ширхэг	13740	24582	18408	11846	5300	14777.5	9820

Зураг 48. ЗӨСТ-үүдэд нийлүүлсэн тэжээлт орчин 2020 он



БҮЛЭГ 6. ЗООНОЗЫН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

ЗӨСҮТ нь ОХУ, БНХАУ, ХБНГУ, БНСУ, АНУ, Казахстан, Япон зэрэг улсын 10 гаруй байгууллагатай хамтын ажиллагаатай ажилладаг. 2020 онд дэлхий нийтэд тархсан коронавирусын цар тахлын улмаас улс орнууд хилээ хааж хамтран ажилладаг байгууллагуудын үйл ажиллагаа энэ халдвартай тэмцэх ажилд шилжсэнтэй холбоотойгоор хамтын ажиллагаа хязгаарлагдмал байдалтай явагдаж байна.

Төвийн хэмжээнд гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан судалгааны “Нохойн популяцийн бэтгийн халдваржилтыг тогтооход копроэсрэг-төрөгч илрүүлэх шинжилгээг ашиглах нь”, “Монгол орны хачиг ба хачгаар дамжих халдварын үүсгэгчийн тархалтын судалгаа” сэдэвт хоёр судалгааны төсөл хэрэгжиж байна. Уг хоёр төслийн хүрээнд 2020 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

6.1 Судалгааны төсөл, хөтөлбөр

“Нохойн популяцийн бэтгийн халдваржилтыг тогтооход копро эсрэг-төрөгч илрүүлэх шинжилгээг ашиглах нь” сэдэвт судалгааны төсөл:

Тус төв нь 2019 оны 07 дугаар сараас эхлэн олон улсын “Пробитас” сангийн санхүүжилтээр “Нохойн популяцийн бэтгийн халдваржилтыг тогтооход копро эсрэг төрөгч илрүүлэх шинжилгээг ашиглах нь” төслийг амжилттай хэрэгжүүлж эцсийн тайланг хүргүүлээд байна.

Төслийн үйл ажиллагааны үр дүнгээс:

1. БНХАУ-ын копро эсрэг төрөгч илрүүлэх худалдааны оношлуурыг Монгол улсад хэрэгжүүлэх бэтгийн жинхэнэ эзний халдваржилтыг тогтоох тандалт судалгаанд хэрэглэх боломжийн талаар дүгнэлт гарсан.
2. Улаанбаатар хотын золбин нохдын бэтгийн халдваржилтыг тогтоосон.
3. Баянхонгор аймгийн Баацагаан, Бөмбөгөр, Галуут сумдын эзэнтэй нохдын халдваржилт, түүнд нөлөөлөх хүний хүчин зүйлийг тогтоов.

4. ЗӨСҮТ-ийн лабораторид Гельминт судлалын онош зүйн болон амь сорьцын лабораториудыг байгуулж, мэргэжилтнүүд энэ талын шинжилгээнүүдийг гүйцэтгэх чадавхитай болсон.
5. “Монгол улсад бэтэг өвчний тандалтын тогтолцоо байгуулах, лабораторийн чадавхийг нэмэгдүүлэх” сургалтыг зохион байгуулж, Зоонозын өвчин судлалын байгууллагуудын болон 21 аймгийн МЭГ-уудын шимэгч судлаачдад бэтэг өвчний жинхэнэ эзний халдваржилтыг тогтоох онолын ба дадлагын хичээлүүдийг зааж сургаж. Энэ нь Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийн “анзаарагддаггүй зоонозын өвчний тандалтын тогтолцоог улсын хэмжээнд нэвтрүүлэх, оношилгооны чадавхийг сайжруулах чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургах” 3.6.2.2.-р заалтыг хэрэгжүүлэх ажлын эхлэл болсон.
6. Төслийн үйл ажиллагаануудыг “Update on progress on CE control in Mongolia” мэдээлэл болгон бэлтгэж ДЭМБ-ын цахим хуудсанд байршуулсан. Эх сурвалж: <https://www.who.int/news/item/01-06-2020-update-on-progress-on-cystic-echinococcosis-control-in-mongolia>
7. Төслийн судалгааны ажлын үр дүнгээр “Баянхонгор аймгийн нохойн популяцийн *Echinococcus spp.*-ийн халдваржилтад нөлөөлсөн хүний хүчин зүйлийг тогтоосон дүн”, “A first record of *Echinococcus canadensis* genotype G6/G7 for stray dogs in Ulaanbaatar, Mongolia” өгүүлүүдийг эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд хэвлүүлэхээр бэлтгэж байна.

“Монгол орны хачиг ба хачгаар дамжих халдварын үүсгэгчийн тархалтын судалгаа” төсөл

АНУ-ын Тайланд дахь Зэвсэгт хүчний анагаахын шинжлэх ухааны хүрээлэн (AFRIMS)-ийн санхүүжилтээр Жорж Масоны их сургууль (GMU), Зоонозын өвчин судлалын үндэсний төвтэй хамтран “Монгол орны хачиг ба хачгаар дамжих халдварын үүсгэгчийн тархалтын судалгаа” төслийн хүрээнд 2020 онд Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Таван толгой дах Зэвсэгт хүчний харъяа сургалтын төв орчим, Дундговь аймгийн Өлзийт, Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Манлай, Ханбогд, Баян-Овоо, Номгон, Хүрмэн, Баяндалай, Ханхонгор сум, Сэлэнгэ аймгийн Мандал, Ерөө, Хүдэр сум, Хэнтий аймгийн Норовлин, Баянхутаг, Баян-Овоо сумын нутгаас нийт 4760 хачиг цуглуулж, зүйлийн бүрдлийг нь тогтоосон. *D.nutalli* хачгийг 70%-ийн спирт бүхий түбэд хийж 4°C-д, *H.asiaticum*, *I.persulcatus* зүйлийн хачгуудыг гүн хөлдөөгчинд хадгалж байгаа бөгөөд молекул биологийн шинжилгээнд хамруулахаар бэлтгэж байна.


6.2 Эрдэм шинжилгээний бүтээл, илтгэл, өгүүлэл

Дэлхий дахинд нийгмийн эрүүл мэндийн ноцтой нөхцөл байдал бий болж коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлын хөл хорио тогтсон байгаа энэхүү ажлын ачаалал их үед төвийн эрдэмтэн, судлаачид эрдэм судлалын ажлаа хичээнгүйлэн хийж ном сурах бичиг – 2, олон улсын импакт фактор бүхий сэтгүүлд судалгааны өгүүлэл – 4, Анагаах ухааны докторын зэрэг горилсон бүтээл – 1, Монголын анагаах ухаан сэтгүүлд судалгааны өгүүлэл – 1, Халдварт

өвчин судлалын Монголын сэтгүүлд судалгааны өгүүлэл - 2 тус тус хэвлүүлэн ажилласан байна.

2020 онд Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс нэг сэдэвт бүтээл 3, дотоодод 4, олон улсад 4 өгүүлэл нийтлүүлсэн байна Өмнөх онтой харьцуулахад илтгэл, өгүүлэл, нэг сэдэвт бүтээлийн тоо эрс буурсан бөгөөд энэ нь дэлхий дахнид тархаж буй коронавирусийн нөхцөл байдалтай холбоотой юм (Зураг 49).

Зураг 49. Эрдэм шинжилгээний бүтээлийн сүүлийн 10 жилийн үзүүлэлт



БҮЛЭГ 7. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

7.1 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт

2020 оны байдлаар ЗӨСҮТ нь ажлын байрны дагалдан сургалт 10 удаа, 12 мэргэжилтэн, цахим сургалт 23 удаа, 1966 мэргэжилтэн, төрөлжсөн мэргэшлийн сургалт 19 мэргэжилтэн, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтанд эмч 7, биологич 16, ажлын байран дээрх тасралтгүй сургалт 36 удаа давхардсан тоогоор 2105 мэргэжилтэн сургалтанд хамруулсан байна (Хүснэгт 35).

Хүснэгт 35. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн сургалт (2019)

Сургалтын төрөл	Давтамж, хамрагдсан мэргэжилтний тоо
Зоонозын өвчин судлал үндсэн мэргэшлийн сургалт	5 Эмч
Ажлын байрны дагалдан сургалт	10 удаа, 12 мэргэжилтэн
Төрөлжсөн мэргэшлийн сургалт	19 мэргэжилтэн
Цахим сургалт	24 удаа
Ажлын байран дээрх тасралтгүй сургалт	36 удаа, 2105 /давхардсан тоогоор/

2020 оны байдлаар ЗӨСҮТ-өөс телемедициний сүлжээ, техник технологийн тусламжтайгаар төрөлжсөн мэргэшлийн зөвлөгөө өгөх, оношлох, эмчлэх үйлчилгээний тусламж үйлчилгээг нийслэл, орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах зорилгоор цахим сургалтад нийт 24 удаа, 261 байгууллагын 1966 хүн хамрагдсан байна. Өмнөх оноос цахим сургалт 4 дахин нэмэгдсэн байна. Цахим сургалтыг төрлөөр ангилан үзэхэд Коронавируст халдвар 50 хувь /12/ Коронавирусийн халдварын сэргийлэлт, хяналт, бэлэн байдал, эрсдлийн үнэлгээ, Коронавируст халдвар (COVID-19)-ын үед ажиллаж буй эрүүл мэндийн байгууллагуудын шуурхай хариу арга хэмжээний багуудын бэлэн байдлын чадавхийг сайжруулах зэрэг сэдвээр, тарваган тахал 41.6 хувь /10/ тарваган тахал өвчний үед авах арга хэмжээ, эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдал, хачигт халдвар 8.3 хувийг /2/ хачигт халдварын хүн амын дундах тандалт судалгааны тойм, эмгэг жам, эмнэл зүй, эмчилгээ, лабораторийн оношилгоо зэрэг сэдвийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудийн мэргэжилтнүүдийг чадавхжуулсан байна (Хүснэгт 36).

Хүснэгт 36. Цахим сургалтын мэдээ 2020 он

№	Сэдэв	Сургалт хийсэн байгууллага	Хамрагдсан байгууллагын тоо	Сургалт зохион байгуулагдсан тоо	Хамрагдсан хүний тоо
1	Коронавирус, өнөөгийн байдал, ДЭМБ-ын зөвлөмж	21 аймаг, нийслэлийн ЭМГ, БОЭТ, НЭ, ЗӨСТ,	43	1 удаа	142
2	Коронавирусийн халдварын сэргийлэлт, хяналт, Skype ЗӨСТ-үүдэд Бэлэн байдал, эрсдлийн үнэлгээ	Нийслэл, Архангай, Баянхонгор аймгуудын ЗӨСТ	3	1 удаа	67
3	Коронавирусийн халдварын сэргийлэлт, хяналт, Skype ЗӨСТ-үүдэд Бэлэн байдал, эрсдлийн үнэлгээ	Баян-Өлгий, Хөвсгөл, Өмнөговь аймгуудын ЗӨСТ	3	1 удаа	55
4	Коронавирусийн халдварын сэргийлэлт, хяналт, Skype ЗӨСТ-үүдэд Бэлэн байдал, эрсдлийн үнэлгээ	Хэнтий, Сэлэнгэ, Говь-Алтай аймгуудын ЗӨСТ	3	1 удаа	57
5	Коронавирусийн халдварын сэргийлэлт, хяналт, Skype ЗӨСТ-үүдэд Бэлэн байдал, эрсдлийн үнэлгээ	Ховд, Дундговь, Увс, Завхан, Өвөрхангай аймгуудын ЗӨСТ	4	1 удаа	76
6	"Тарваган тахал өвчний үед авах арга хэмжээ, эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдал"	Ховд, Говь-Алтай аймгуудын ЭМГ, БОЭТ, НЭ, өрхийн эмнэлэг, сумдын нэгдсэн эмнэлэгүүдэд	11	1 удаа	78
7	Тарваган тахал өвчний үед авах арга хэмжээ, эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдал"	Архангай, Булган аймгуудын ЭМГ, НЭ, өрхийн эмнэлэг, сумдын нэгдсэн эмнэлэгүүдэд	18	1 удаа	123
8	"Тарваган тахал өвчний үед авах арга хэмжээ, эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдал"	Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудын ЭМГ, НЭ, өрхийн эмнэлэг, сумдын нэгдсэн эмнэлэгүүдэд	17	1 удаа	114
9	"Тарваган тахал өвчний үед авах арга хэмжээ, эрүүл	Баянхонгор, Өвөрхангай	19	1 удаа	137


	мэндийн байгуулагуудын бэлэн байдал"	аймгуудын ЭМГ, НЭ, өрхийн эмнэлэг, сумдын нэгдсэн эмнэлэгүүдэд			
10	"Тарваган тахал өвчний үед авах арга хэмжээ, эрүүл мэндийн байгуулагуудын бэлэн байдал"	Хөвсгөл, Орхон, Дархан уул аймагуудын ЭМГ, НЭ, өрхийн эмнэлэг, сумдын нэгдсэн эмнэлэгүүдэд	15	1 удаа	98
11	"Тарваган тахал өвчний үед авах арга хэмжээ, эрүүл мэндийн байгуулагуудын бэлэн байдал"	Дундговь, Өмнөговь аймагуудын ЭМГ, НЭ, өрхийн эмнэлэг, сумдын нэгдсэн эмнэлэгүүдэд	16	1 удаа	132
12	"Тарваган тахал өвчний үед авах арга хэмжээ, эрүүл мэндийн байгуулагуудын бэлэн байдал"	Төв, Сэлэнгэ, Говьсүмбэр аймагуудын ЭМГ, НЭ, өрхийн эмнэлэг, сумдын нэгдсэн эмнэлэгүүдэд	5	1 удаа	39
13	Хачгаар дамжих халдварын байгалийн голомтын болон хүн амын дундах тандалт судалгааны тойм, эмгэг жам, эмнэл зүй, эмчилгээ, лабораторийн оношилгоо	Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Хөвсгөл, Увс, Өмнөговь, Өвөрхангай аймагуудын нийт 133 эмч мэргэжилтэн	38	2 удаа	133
14	Хачгаар дамжих халдварын байгалийн голомтын болон хүн амын дундах тандалт судалгааны тойм, эмгэг жам, эмнэл зүй, эмчилгээ, лабораторийн оношилгоо				
15	Ховд аймагт гарсан тарваган тахлын үед аймгийн ЭМГ, НЭ, Ховд аймгийн ЗӨСТ, Засаг даргын тамгын газруудтай холбогдож тухай бүрт мэргэжил арга зүйн зөвлөгөө	Ховд аймгийн ЗӨСТ, БОЭТ, ЭМГ	3	2 удаа	88
16	Тарваган тахал өвчний байгалын голомтын төлөв байдал, тарваган тахал өвчний үед авах хариу арга хэмжээ, эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал, тарваган тахал	21 аймаг, нийслэлийн ЭМГ, БОЭТ, НЭ, ЗӨСТ,	41	1 удаа	194

	өвчний эмнэл зүй, эмчилгээ, лабораторийн оношилгоо, сорьц авах, тээвэрлэх, биоаюулгүй ажиллагаа, тарваган тахал өвчний дархлаажуулалт				
17	Коронавируст халдвар (COVID-19)-ын үед ажиллаж буй эрүүл мэндийн байгууллагуудын шуурхай хариу арга хэмжээний багуудын бэлэн байдлын чадавхийг сайжруулах зорилгоор 2020 оны 12-р сарын 09-31 хооронд цахим цуврал сургалт	Ортопед, мэргэжлээс шалтгаалах өвчний төв	19	7 удаа	375
18		Ахуйн шавьж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйтгэлийн ахуйн нэгжүүд			
19		Тусгаарлах байранд ажиллаж буй резидент эмч нарт			
20		ЭМЯ-ны харъяа тусгай мэргэжлийн төвүүд			
21		Нийслэлийн өрхийн эрүүл мэндийн төвүүд			
22		Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд			
23		Нийслэлийн түргэн тусламжийн төв			
24	Увс аймгийн ЗӨСТ, Засаг даргын тамгын газруудтай холбогдож тухай бүрт мэргэжил арга зүйн зөвлөгөө	Увс аймгийн ЗӨСТ, ЭМГ, НЭ	3	2 удаа	58

7.2 Хүн амын дундах сургалт, сурталчилгаа


2020 онд Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн цахим хуудсанд нийт 310 шинэ мэдээ нийтлэгдэж, 181513 хандалттай байна. Нийт мэдээнээс 71.3 хувь ЗӨСҮТ, 28.7 хувь орон нутгийн ЗӨСТ-өөс иргэдэд зориулсан зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдлэг олгох мэдээлэл, байгууллагын үйл ажиллагааны цаг үеийн мэдээ, мэдээллийг нийтэлсэн байна. Өмнөх оноос хандалт 2.3 дахин нэмэгдэж, нийтлэсэн мэдээ 9.1 хувиар буурсан байна (Зураг 50).

Зураг 50. Вэбийн нийтлэсэн мэдээ, хандалт 2015-2020 он



Нийт орон нутгийн ЗӨСТ-үүдээс нийтлүүлсэн мэдээнээс Архангай, Өмнөговь, Хөвсгөл аймаг нийтлүүлсэн мэдээгээр өндөр үзүүлэлттэй байна. Харин Баян-Өлгий, Нийслэл, Увс аймгууд мэдээ нийтлүүлээгүй байна (Зураг 51).

Зураг 51. 2020 онд вэбэд нийтлүүлсэн мэдээ аймгаар




Нийт мэдээнүүдийг агуулгаар нь ангилахад цаг үеийн мэдээ 31.8 хувь, сургалт 14.2 хувь, зөвлөгөө 18 хувь, зоонозын өвчний мэдээ 9.2 хувь, бусад мэдээ 16.2 хувь, тандалт 10.5 хувийг тус тус эзэлж байна. Мөн байгууллагын төрлөөр ангилахад ЗӨСҮТ 68 хувь, ЗӨСТ 28 хувь, ЭМЯ 3 хувь, ҮЭХ 1 хувийг тус тус эзэлж байна (Зураг 52).

Зураг 52. Вэйв хуудасны мэдээний байгууллагын төрлөөр




Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн (Зоонозын өвчин судлалын үндэсний төв) фэйсбүүк пэйж хуудсад нийт 564 мэдээ, мэдээлэл нийтэлж хандалт 2,413,837 байна. Сараар нь харьцуулж үзэхэд 11,12 саруудад нийтэлсэн мэдээлэл өндөр үзүүлэлттэй байна. Энэ дотоодод коронавируст халдвар тархсантай холбоотой урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэх мэдээллийг олон нийтэд хүргэсэн (Зураг 53).

Зураг 53. Мэдээ, мэдээлэл түгээсэн хэлбэр (сараар)




Зоонозын өвчлөл, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг 16 телевизээр (MNB, TV9, 25TV, Bloomberg, Like HD, Малчин HD, MNBC, Parliament, Сүлд, TV5, TV4, Star, TV6, Малчин бирж, C1, MYOHT, ETV) 58 удаа, олон нийтийн мэдээллийн 38 сайтаар (ikon.mn, gogo.mn, socialmedee.mn, zindaa.mn, mnb.mn, gogo.mn, eguur.mn, likeHD.mn) 124 удаа, лайв хэлбэрээр 22 удаа, 4 сонинд (Өнөөдөр, Үндэсний шуудан сонин, МҮОЭР) 21 удаагын давтамжтайгаар түгээсэн байна. Мөн урсдаг мэдээ: 8 телевизэд 405 мэдээ 810 удаагын давтамжтайгаар түгээсэн байна (Зураг 54).

Зураг 54. Олон нийтэд мэдээ мэдээлэл түгээсэн хэлбэр



Төвийн цахим хуудас, фэйсбүүк хуудасны хандалт өмнөх оноос 2 дахин өссөн үзүүлэлттэй байна (Зураг 55).

Зураг 55. Фэйсбүүк болон цахим хуудасны хандалт



7.3 Дархлаажуулалт

Зоонозын өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын үйл ажиллагааг “Дархлаажуулалтын тухай” Монгол улсын хууль, Дархлаажуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 67 дугаар тогтоол, Тархвар судлалын заалтаар нэмэлт дархлаажуулалт хийх тухай ЭМС-ын 252 тоот тушаал, “Халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний улсын фондын вакцин, ийлдэс, биобэлдмэлийг зарцуулах тухай ЭМС-ын 261 тоот тушаал зэрэг эрхзүйн актуудыг мөрдөж зохион байгууллаа.

2020 оны захиалгат хачигт энцефалитын вакцин 15400 хүн тун, тарваган тахал 25400 хүн тун, ХЭ ийлдэс 3650 тун шил, галзуугийн ийлдэс 600, галзуугийн вакцин 1800, томуугийн вакцин 110 х/т хүлээн авсан. Зоонозын вакцины сар бүрийн зарцуулалтын болон дархлаажуулалтын мэдээ тайлан нэгтгэн хүргүүлсэн.

Зоонозын өвчний дархлаажуулалтын 2021 онд хийгдэх захиалгыг аймаг нийслэлээс онлайнаар авч нэгтгэн ХӨСҮТ-д хүргүүлээ. ХӨДББН болон тархвар судлалын заалтаар 2021 онд хачигт энцефалит 13540 хүн тун, тарваган тахал 66150 хүн тун, боом 5600 хүн тун, галзуу 17000 хүн тун, галзуугийн ийлдэс 470 тун шил, хачигт энцефалитын ийлдэс 2650 тун шил захиалсан.


ЗӨСҮТ-ийн ажилчдыг томуугийн вакцинд хамруулж, мэдээг ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанд хүргүүлсэн.

Зоонозын өвчний эсрэг дархлаажуулалт:

Тарваган тахлын голомтот нэмэгдэж идэвхижиж байгаатай холбоотой жил бүр хамрагдах хүний тоо нэмэгдэж байна.

Хачигт энцефалитын өвчлөл нэмэгдэж байгаатай холбоотой голомтот нутгийн хүн амыг дархлаажуулалтанд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлж голомтот нутгийн зорилтот бүлгийн хүн амыг дархлаажуулах зорилго тавин сүүлийн 2 жилд хамрагдах зорилтот бүлэг болон захиалгыг 1.2 дахин нэмэгдүүлэн ажиллаж байна. Голомтот нутгийн зорилтот бүлгийн вакцинд хамрагдах хүний тоог тарваган тахал, хачигт энцефалитын вакцинд 35% иар нэмэгдүүлэн хамралтын хувь 92,1- 92,7% тай. Галзуу өвчний сэжигтэй мал, амьтанд уруулж ноцуулж галзуугийн вакцин 7731 хүн тариулсан байна (Зураг 56).


Зураг 56. Зоонозын өвчний дархлаажуулалтын хамралтын хувь 2015-2020 он



7.3.1 Тарваган тахлын дархлаажуулалт:

Тарваган тахлын байгалийн голомтын эпизооти нэмэгдсэнтэй холбогдуулан хамрагдах хүний тоог 40 хувиар нэмэгдүүлж, 2020 оны 6 дугаар сарын 15 ны өдрөөс 7 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулан 17 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт 54000 хүн тун вакцин хүргүүлж, 50100 хүнийг хамруулсан ба 92.7%-ийн хамралттай (Зураг 57).

Зураг 57. Тарваган тахлын дархлаажуулалт 2010-2020 он



7.3.2 Хачигт энцефалитын эсрэг дархлаажуулалт:

2020 онд хачигт энцефалитын вакциныг 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэг, бусад байгууллагын эрсдэлт бүлгийн 12552 хүнийг хамруулсан ба 92.1%-ийн хамралттай. Хачигт энцефалитын халдвар авч, хүндрэн эмчилгээ хийгдсэн 23 хүнд 2295 мл ийлдэс зарцуулагдсан. Хачигт энцефалитын вакцин 2020 онд 15000 хүн тун вакцин захиалж төлөвлөснөөс 21 аймаг, 4 дүүрэг, НОБГ, Үндэсний аврах бригад., Ой агнуурын газар, Ойн судалгаа хөгжлийн төв, Зэрлэг амьтан судлах төв, Хилийг цэргийн ...дугаар хилийн застав, ЗӨСҮТ-ийн мэргэжилтнүүд нийт 1

тунд 4595, II тунд 1715, II тунд 1977, сэргээх тунд 530 хүн хамрагдаад байна (Зураг 58).


Зураг 58. Хачигт энцефалитын дархлаажуулалт 2010-2020



7.3.3 Галзуугийн эсрэг дархлаажуулалт:

2020 онд галзуу өвчний сэжигтэй мал, амьтанд уруулж ноцуулсны улмаас галзуу өвчний эсрэг вакцинд 7731 хүн хамрагдсаны 15.1% нь вакцин дутуу орхисон байна. Яаралтай захиалгын дагуу мал амьтанд уруулж, ноцуулж, шүлсдүүлсний улмаас 11 хүнд 230 мл галзуугийн ийлдэс эмчилгээнд хамрагдсан байна (Зураг 59).

Зураг 59. Галзуугийн вакцинд хамрагдсан байдал 2010-2020



7.3.4 Боом өвчний дархлаажуулалт:

Боомын эсрэг вакцин олон тунтай, гаж нөлөө өндөр байгаа тул хүмүүс хийлгэхэд татгалзах, бүрэн тунгийн хамралт муу байна. Боомын дархлаажуулалтын үйл ажиллагаа хангалтгүй, боомын вакцины 1 хүнийг дархлаажуулах өртөг эмчилгээний зардлаас өндөр байгаа нь урьдчилан сэргийлэх нь эмчлэхээс хялбар зарчимтай нийцэхгүй байна. Боомын дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах тогтоол, журмыг шинэчлэх, одоогийн хэрэглэж байгаа вакциныг солих. (цөөн тунтай вакцинаар) , дархлаажуулалтанд зарцуулагдаж буй зардлыг боом өвчнөөс урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээнд зарцуулах боломжийг судлах шаардлагатай байна гэсэн судалгааны 2020 онд боомын вакцин хийгдээгүй.

7.3.5 Дархлаажуулах бэлдмэлийн хадгалалт, тээвэрлэлт

Вакцин ийлдсийн хүйтэн хэлхээ, тоног төхөөрөмжийн тээвэрлэлт, хадгалалтанд хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хэмийн заалтыг өдөрт 2 удаа дуудлага хяналтын бага эмч нараар тэмдэглүүлж, хяналт тавьж, сар улирлын тооллого хийн, зарцуулалтын тайланг ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанд хугацаанд нь илгээсэн.

Зоонозын өвчнөөс сэргийлэх вакцин, ийлдсийн хэрэглэх заавар, урвал хүндрэлийн талаар төвийн болон орон нутгийн эмч, мэргэжилтнүүдэд мэдээлэл өгч мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.

Хугацаа дууссан тарваган тахлын вакцин 110 ампул, хачигт энцефалитын ийлдэс 430 ампулыг ЭМС-ын 2011 оны 359 тоот тушаал, Төвийн захирлын 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн А/28 тоот тушаалаар ажлын хэсэг томилуулж вакцин устгал хийж протокол болон акт үйлдсэн байна.

Зоонозын өвчний вакцин ийлдэс нь тендерээр худалдан авалт хийгддэг тул улсын бүртгэлд ороогүй гэсэн шалтгаанаар жил бүр хугацаа хоцордог хүндрэлтэй байдал үүсдэг. 2020 оны вакцин биобэлдмэлийн захиалга нийлүүлэлтэнд хугацаа хоцрох тасалдалт үүсээгүй.

8. ТАНИН МЭДЭХҮЙ

8.1 Зоонозын өвчний төрөл

Шинэ болон сэргэн тархаж буй Зоонозын өвчин бол хүн төрөлхтний дунд өмнө байсан болон шинээр гарч ирсэн өвчнүүд бөгөөд газарзүйн хүрээний хувьд хурдацтай тархаж буй өвчин юм. Гэхдээ зоонозын өвчин нь ихэвчлэн үхэлд хүргэдэггүй бөгөөд ихэнх нь өргөн тархдаггүй. Гэхдээ шинээр гарч ирж буй зарим өвчин асар их нөлөө үзүүлдэг. Эбола, ХДХВ/ДОХ, одоо COVID-19 нь хүний эрүүл мэнд, эдийн засагт онцгой хор хөнөөл учруулж буй зоонозын өвчин юм.

8.2 Шинэ ба сэргэн тархаж байгаа өвчнүүд

Эдгээр нь шинээр бүртгэгдсэн болон өмнө нь бүртгэгдэж байсан ч тохиолдлын тоо, газарзүйн тархалтын хувьд хурдацтай нэмэгдэж байгаа өвчнүүд юм. Сүүлийн үед шинээр гарч буй эбола, ХДХВ, Ковид-19 өвчнүүдийн нөлөө асар их байна.

Эболагийн дэгдэлт – Гвиней, Либер, Сейра-Леон улсуудад 2013-2016 онд – 11 323 нас баралт, 2.8 тэрбум ам. долларын эдийн засгийн хохирол учруулсан.

Зика вирусийн дэгдэлт – Америк тивд 2015-2016 онд. Зика вирусын халдвар авсан жирэмсэн эмэгтэйчүүдийн 7 хүүхэд тутмын 1 нь мэдрэлийн өвчтэй болдог. Зикагаас үүдэлтэй тархи жижигрэх өвчний тохиолдол тутамд 912 000 ам. долларын зардал гардаг (Зураг 60).

Зураг 60. Шинэ ба сэргэн тархаж буй өвчний тархалт



8.3 Эпидемик (голомтот) зоонозын өвчнүүд

Тодорхой нутаг дэвсгэрт үе үе гардаг өвчнүүд. Жишээ нь боом, лейшманиаз, Рифт хөндийн чичрэг гм. Эдгээр өвчнүүд нь уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын гэнэтийн үзэгдлүүд болон өлсгөлөн мэтийн нийгэм ахуйн үзэгдлүүдээс үүдэлтэй байдаг. Дэгдэлт, тахлаас үүдэлтэй хохирол нь анзаарагддаггүй зоонозын өвчнүүдийхээс бага боловч хүнсний болон бусад салбаруудад хүчтэй цохилт болдог учир амьжиргааны түвшин доогуур хүмүүст хүнд дарамт учруулдаг.

Мавритан улсад 2015-2016 онд Эль Нино хэмээх далайн хар салхинаас үүдэлтэй Рифт хөндийн чичрэгийн дэгдэлт болсон.

Сибирийн Ямалын хойгт 2016 онд мөнх цэвдэгт удаан хугацаагаар хайлснаас боом өвчин дэгдсэн.

8.4 Анзаарагддаггүй зоонозын өвчнүүд

Ихэвчлэн нутагшмал бөгөөд тодорхой хүн амд их бага хэмжээгээр тасралтгүй оршдог. Эдгээр нийтлэг өвчнүүд нь ядуу байдлаас үүдэлтэй, өвчилснөөр амьжиргаанд нөлөөлж ядууралд хүргэдэг бөгөөд олон улсын хандивлагчид, стандарт тогтоогчид, судалгааны нийгэмлэгүүд болон үндэсний засгийн газруудын үл тоомсорлолтой холбоотой. Эдгээр өвчний илрүүлэлт, тандалт

судалгааны ажлууд муу байгаа бөгөөд судлаачид, бодлого боловсруулагчид анхааралдаа авч, эрэмбэлэх шаардлагатай байна.

Гахайн туузан хорхойн үр дагавар

- Дэлхий даяар 50 сая хүн өвчилсөн.
- Тэдний 80% нь хөгжиж буй орнуудад амьдардаг.
- Энэтхэг улсад жил бүр 150 сая долларын зардал гардаг.

8.5 Зоонозын өвчнүүдийн хүний өвчлөлийн дэгдэлт ямар үед болдог вэ?

Хүн төрөлхтний түүхэн хөгжлөөс үүнийг харж болох юм. Хүмүүс амьтадтай хэрхэн харилцаж байснаас эдгээр өвчнүүдийн холбогдол шууд хамааралтай байжээ. Чулуун зэвсгийн үед хүмүүс анчин амьдралын хэлбэрээс хөдөө аж ахуйн амьдралын хэлбэр лүү шилжих шилжилтийн үед чанар муутай бага хэмжээний хоол хүнс хэрэглэж байснаас бие давжаарч, өвөг дээдсээсээ ч илүү өвчилж, богино насалдаг байжээ. Хөдөө аж ахуй бүрэн нэвтэрснээр хүн амын тоо хурдацтайгаар өссөн ч хогноос үүдэлтэй өвчин ихэссэн. Мөн амьтдыг гаршуулж, мал аж ахуй эрхлэх болсноор малын эмгэг төрүүлэгчид хүмүүст халдан сахуу, томуу, улаан бурхан, салхин цэцэг өвчнүүд гарах болсон.


Нийгмийн томоохон хямрал, үймээн самуунтай холбоотойгоор зоонозын өвчнүүдийн тахал, дэгдэлтүүд эхлээд амьтнаас хүнд халдсан бол сүүлдээ хүнээс хүнд халддаг болсон байна. Эндээс зарим томоохнуудыг нь дурьдвал:

1. Еврази, Хойд Америкт 14-р зууны дунд үед тарваган тахлын булчирхайн хэлбэрийн цар тахал болж, Европын нийт хүн амын 3-ны 1-ийг авч одсон.
2. XVI зуунд европчууд Америк тивд ирснээр Европ тивд дэлгэрсэн өвчнүүдийн халдварыг шинэ тивд тарааснаар уугуул иргэдийн 95% нь үхэж, соёл иргэншил нь устсан байна. Эсрэгээрээ шинэ тивээс хуучин тиврүү олон зүйлийн амьтан, ургамал шилжүүлэн нутагшуулснаар тэдэнтэй хамт олон өвчин үүсгэгчд шинэ тив рүү шилжиж, илүү эрсдлийг бий болгосон.
3. Баруун Европ дахь аж үйлдвэржилт, хүн амын хэт төвлөрөлтэй холбоотойгоор XIX зуунд дэгдсэн сүрьеэгийн дэгдэлт нь дөрвөн хүн тутмын нэгний аминд хүрсэн юм. Өнөө цагт тохиож буй сүрьеэгийн тохиолдлуудаас ялгаатай нь тухайн үеийн тохиолдлуудын ихэнх нь зоонозын гаралтай сүрьеэ байжээ.
4. Африк тивийг колоничлсонтой холбоотойгоор XX зууны эхний арван жилд зоонозын унтах өвчний дэгдэлт гарч, Уганда улсын 3 хүн тутмын 1, Конго мөрний савгазрын 5 хүн тутмын 1 нь нас баржээ.
5. 1918 онд дэгдсэн томуугийн цар тахлаар дэлхийн нэгдүгээр дайны сүүлийн саруудад болон дараа жилүүдэд 40 сая орчим хүн амиа алдсан (1918–1921).

Allen нар (2017) халуун орны ой бүхий бүс нутгийн тархалт, хүн амын нягтшил, хөхтөн амьтдын төрөл зүйлийн баялаг, хөдөө аж ахуйн зориулалттай газар ашиглалт гэх мэт олон төрлийн таамаглалд үндэслэн зэрлэг ан амьтдын гаралтай шинээр хүн амд шинээр болон сэргэн тархаж болзошгүй халдварт

өвчин (EID) -үүдэд дүн шинжилгээ хийсэн. Шинжилгээний дүнгээр шинэ болон сэргэн тархаж байгаа өвчнүүдийн эрсдлийн магадлалыг үзүүлжээ (Зураг 61).

Зураг 61. Зоонозын өвчин үүсэх эрсдлийг тооцоолсон дэлхийн халуун цэгийн зураг



Коронавирус болон бусад вирусээр үүсгэгддэг зарим



1931

Шувууны халдварт бронхит

Үүсгэгч: Халдварт бронхитвирус (IBV)

Төрөл: Гаммакоронавирус

Эзэн: Тахиа

Үүссэн газар: Хойд Дакота, АНУ. Шувууны халдварт бронхит нь тахианаас хүнд халдварладаг амьсгалын замын гоц халдварт өвчин юм. Энэхүү халдвар нь тахианы нөхөн үржихүйн тогтолцоог гэмтээж өндөгний чанар, бүтээмжийг бууруулдаг. Анхны тохиолдол АНУ-д бүртгэгдэж, шувууны аж ахуй эрчимтэй хөгжиж буй улс орнуудад тархсан.



1971

Гахайн тахлын суулгалт

Үүсгэгч: Гахайн тахлын суулгалтын вирус (PEDV)

Төрөл: Альфакоронавирус

Эзэн: Гахай

Үүссэн газар: Их Британи

Анхны тохиолдол Англи улсад бүртгэгдэж, Ази болон Европын бусад улс орнуудад тархсан. 2013 онд өндөр хоруу чанартай PEDV вирусийн омог АНУ-д үндэсний хэмжээнд тархаж, Хойд, Төв болон өмнөд Америкийн улс орнуудад тархсан. Энэ нь зоонозын өвчин биш бөгөөд хүн ам болон хүнсний аюулгүй байдалд ямарч нөлөөгүй.



2003

Амьсгалын цочмог халтай хам шинж (SARS)

Үүсгэгч: SARS коронавирус

Төрөл: Бетакоронавирус

Эх уурхай: Туурай хоншоорт сарьсан багваахай

Завсрын эзэн: Сүүлт суусар

Үүссэн газар: БНХАУ, Гуандон. БНХАУ-ын Гуандон мужад уушгины хатгалгаа төст халдвар анх бүртгэгдсэний дараа Ази, Европ, Хойд Америк, Өмнөд Америкийн 16 гаруй оронд тархсан байна. АЦХХШ төст коронавирсийн байгаль дах эх уурхай нь сарьсан багваахай гэж үзэж байна.

1920



1920

Хүний дархлал хомсдлын вирус (ХДХВ)

Үүсгэгч: ХДХВ вирус

Төрөл: Лентивирус

Халдварын эх уурхай:

ХДХВ/ДОХ-той хүн

Үүссэн газар: Киншаса, Бүгд найрамдах ардчилсан Конго улс

ХДХВ -ийг анх 1983 онд хүнээс илрүүлсэн ч вирусийн филогеографын шинжилгээ хийж, 1920-иод оны үед Киншаса хотод анх дархлал хомсдолын вирус анх бий болон үржиж эхэлснийг тогтоосон бөгөөд чухам эндээс тив дэлхий даяар ХДХВ тархсан хэмээн үзэж байна.

1930



1937

Баруун нилийн чичрэг

Үүсгэгч: Баруун Нилийн вирус

Төрөл: Флавивирус

Эзэн: Шувуу

Үүссэн газар: Уганда

хотын Баруун нил муж. Шумуул нь тус вирусийн дамжуулагч болдог бөгөөд халдвартай шувуунаас хүн болон зарим хөхтөн амьтдад вирусийг тараадаг. Анхны дэгдэлт 1951 онд Израиль, дараа нь Египтэд гарсан. Мөн 1996 онд Румын улсад дахин дэгдэж, 1999 оноос хойш АНУ-д бүртгэгдэж байна. Баруун Нилийн чичрэг нь денге, шар чичрэг өвчний нэг төрөлд багтдаг.

1940



1947

Зика вирус

Үүсгэгч: Зика вирус (ZIKV)

Төрөл: Флавивирус

Эх уурхай: Сармагчин, хүн

Үүссэн газар: Уганда улсын Зика ой.

Анхны тохиолдол Зика ойн резус сармагчинаас, үүнээс жилийн дараа Aedes africanus зүйлийн шумуулнаас илрүүлжээ. Хүний овчлолийн анхны тохиолдол 1952 онд Уганда болон Танзани улсад бүртгэгдсэн байна. 2007 онд Микронезийн Холбооны Улс болох Яп арал дээр дэгдэлт гарч, дараа нь 2015-2016 онд Америк тивд том хэмжээний тахал гарчээ.

1950

1970



1976

Эбола вирус

Үүсгэгч: Эбола вирус

Төрөл: Эболавирус

Эх уурхай: Баталгаагүй

боловч Африкийн жимсний сарьсан багваахай байх магадлалтай

Завсрын эзэн: Мич ба Сармагчин

Үүссэн газар: БНАКУ ба Өмнөд Судан улсад зэрэг дэгдэлт гарсан.

Түүхэн дэх хамгийн том дэгдэлт нь 2014-2016 онд Гвиней, Сьерра-Леон, Либери зэрэг улсад гарч, 11,323 хүн нас барсан. Сүүлд 2018-2019 оны хооронд БНАКУ-д дахин дэгдэлт гарсан. Эбола вирусны нас баралтын хувь 25-90% хооронд хэлбэлзэж байна.

Коронавирус болон бусад вирусээр үүсгэгддэг зарим өвчнүүд



1980 1990 2000 2010 2020

